


“Бэлчээрийн менежмент-төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1/ дугаар тушаалын хавсралт



АЖЛЫН БАЙР /АЛБАН ТУШААЛ/-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

А. ТАНИЛЦУУЛГА

1. Байгууллагын нэр: Бэлчээрийн менежмент төслийн нэгж		2. Нэгжийн нэр: Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар	
3. Ажлын байрны нэр: Агрономч		3.1. Албан тушаалын ангилал: Мэргэжлийн албан хаагч	3.2. Албан тушаалын зэрэглэл: ТУ-7
4. Ажлын байрыг шууд харъяалан удирдах албан тушаалын нэр : Байгууллагын дарга		4.1. Албан тушаалын ангилал: Ахлах түшмэл	4.2. Албан тушаалын зэрэглэл: ТУ-12
5. Ажлын байрны шууд харъяалан удирдах албан тушаал	5.1. Албан тушаалын нэр:		5.2. Албан тушаал эрхлэгчдийн тоо
	Газрын Дарга Бусад ажилтан		1 8

Б.ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго	Төслийн болон нөөц талбайн хөрсний үржил шимийг тогтоон судалгаа шинжилгээ хийх, хадлан бэлчээрийн талбайг нөхөн сэргээх, ургацын хэмжээ, чанарыг сайжруулах, кабинетийн сургалтуудыг малчдын дунд зохион байгуулах		
2. Ажлын байрны үндсэн зорилт		2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
1.Төслийн шинэ дэвшилтэт технологийн дагуу хашаалсан бэлчээрийн талбайд бууц/органик бордоо/, нийлмэл эрдэс бордоо цацах зориулалт бүхий техникүүдийг ашиглан хөрсний үржил шимийг сайжруулах		Бэлчээрийн талбайн ашиглалт сайжирч, хөрсний үржил шим дээшилж, нэгжээс хураан авах ногоон тэжээлийн ургацын хэмжээ нэмэгдэнэ.	
2.Хашаалсан бэлчээрийн талбайг хагалахгүйгээр тэжээлийн олон наст холимог үрийг зориулалтын техникээр тарьж, хольц ургамал бүхий витаминт ногоон массын ургацыг хураан авч вакумжуулан хадгалах замаар шимт чанар өндөртэй ногоон тэжээлийг бэлтгэн үнээг тэжээсний дүнд сүүний гарцыг нэмэгдүүлэх		Олон наст таримлын холимогоос бүрдсэн шинэ витаминт ногоон тэжээл хураан авна. Фермийн үнээний сүүний гарц нэмэгдэнэ.	
3. Ажлын байрны гол үйл ажиллагаа			3.1. Хугацаа, хуваарь
Хөрсний чанар үржил шим сайжруулах, бэлчээрийн талбайн ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг хариуцаж, зохион байгуулах. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар эх орны хөрсөнд ургасан витаминт ногоон масс бүхий тэжээлийг зах зээлд			

нийлүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээ зохион байгуулах. Шинэ дэвшилтэт технологийн дагуу олон наст таримлын холимог үрээр тариалалт хийж, ногоон тэжээл хураан авахтай холбоотой Агро технологийн карт боловсруулж батлуулах. Батлагдсан Агротехнологийн картын дагуу тариалалтын ажлыг цаг хугацаанд нь чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх. Органик бордоо ашиглах туршилтын ажлыг зохион байгуулах, Тариалсан талбайн ургацад ажиглалт, судалгаа явуулах, удирдлагуудыг мэдээллээр хангах. Фермерийн аж ахуй эрхлэгчид, малчдад зөв зохистой тэжээл үйлдвэрлэх, түүнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар сургалт зөвлөгөөг хамтран зохион байгуулах.	
---	--



В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1. Ерөнхий шаардлага:	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		Боловсрол	Дээд боловсролын бакалавр, магистрын зэрэг түүнээс доошгүй зэрэгтэй байх.	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй
		Мэргэжил	Агрономч	Хөдөө аж ахуй газар тариалангийн чиглэлээр дээд мэргэжил эзэмшсэн
		Мэргэшил	Мэргэжлийнхээ дагуу судалгаа шинжилгээ хийж байсан	Өөрчлөлтийг манлайлах, бизнес сэтгэлгээтэй байх
		Туршлага	5-с доошгүй жил ажилласан байх	Салбартаа 3-с доошгүй жил ажилласан байх
		Ур чадвар	Багаар ажиллах, удирдан зохион байгуулах, Хэрэглээний программууд дээр ажиллан албан бичиг баримт боловсруулах, Харилцааны соёлтой, хариуцсан ажлаа бие даан гүйцэтгэх, хариуцлага хүлээх чадвартай,	Компьютерийн өргөн хэрэглээний программуудыг ашиглаж чаддаг байх
	1.2. Тусгай шаардлага:	Тухайн цаг үеийн нөхцөл байдалд бодитой хандах, түүнд зохицон ажиллах бүрэн боломжтой байх,	Үнэнч шударга, Шуурхай ажиллах, эрх мэдлийнхээ хүрээнд бусдад нөлөөлөх	

Г. ХҮЧИН ЗҮЙЛС

1. Ажлын байрны харилцах субъект		
1.1. Байгууллагын дотор талд байгаа	1.2. Байгууллагын гадна талд байгаа	
Байгууллагын дарга Төслийн менежер Нягтлан бодогч Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн Механикч Тоног төхөөрөмжийн оператор Фермер Нярав Манаач	Мэргэжлийн хяналтын газар Мэргэжлийн нийгэмлэг, хоршоод, холбоодууд Аж ахуйн нэгж байгууллагууд Иргэд ХАА-н мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургууль, коллеж	
2. Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага	Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль, Ажлын байрны тодорхойлолтоор тогтоосон үүрэг, Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ёс зүйн дүрэм, ажил үүргийн хуваарийн хариуцаж буй хүрээнд шууд удирдах албан тушаалтны өмнө дээрхи хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.	
3. Ажлын байрны нөөц, хэрэгсэл	3.1. Санхүүгийн	Цалин хөлс нь ТҮ-7 зэрэглэлээр ЗГ-ын хүчин төгөлдөр эрх зүйн актуудаар тогтоосон албан тушаалын цалин болон ур чадварын нэмэгдлээс бүрдэнэ. Мөн хоолны болон унааны, бусад хөнгөлөлт, тэтгэмжид хамрагдана.
	3.2. Материалын	Ажлын хувцас, ажлын өрөө ширээ сандал, компьютер шүүгээ, дагалдах бусад хэрэгсэл, бусад шаардлагатай багаж хэрэгсэл
	3.3. Хүний	-
	3.4. Бусад	-
4. Ажлын байрны нөхцөл	4.1. Ердийн нөхцөл	Ажлын хэвийн орчин нөхцөлд ажиллана.
	4.2. Онцгой нөхцөл	Шаардлагатай үед илүү цагаар ажиллах Ажлын байрны нөхцлөө сайжруулах Мэргэшүүлэх чиглэлээр сургалтад хамрагдах Ажлын зайлшгүй шаарлагаар илүү цаг ажиллах, нууц хадгалах, албан ёсны арга хэмжээнд оролцох.

Д. БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан албан тушаалтан	Ажлын байрны тодорхойлолтыг баталсан эрх бүхий албан тушаалтан
Албан тушаалын нэр: Төслийн менежер  Г.ПҮРЭВСҮРЭН	Албан тушаалын нэр: Байгууллагын дарга / тамга /  Г.ГАЛДӨЛ
2018 оны 04-р сарын 06-ны өдөр	2018 оны 04-р сарын 06-ны өдөр 6046231-1116117863